



СҮХБААТАР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 12 сарын 10 өдөр

Дугаар 04

Баруун-Урт

Г Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл
ажиллагааны хөтөлбөрийг батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх хэсгийн “д”, 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Гуравдугаар Хурлаас ТОГТООХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг ханган ажиллахыг Засаг дарга /М.Идэрбат/-д үүрэг болгосугай.



010001.6

Сүхбаатар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2020.оны 10.дугаар сарын 14.-ны
04 дүгээр тогтоолын хавсралт

СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн үр дунд шинээр томилогдсон Засаг дарга нь Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нийцүүлэн нам, иргэний нийгмийн байгууллагууд, иргэд, олон нийтийн саналд үндэслэн 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрөө дэвшүүлж байна.

Аймгийн Засаг дарга 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрөө боловсруулахдаа халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг амжилттай даван туулж, хүн, эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангах, байгаль орчны тэнцвэртэй байдал, засаглалыг сайжруулах, орон нутгийг хөгжүүлэх, төрийн бодлогын залгамж чанарыг хадгалахад онцгой анхаарч, дараах зургаан багц асуудлын хүрээнд 121 зорилт дэвшүүлж, 446 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тодорхойллоо.

НЭГ.“КОВИД-19” ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ

1.1. КОВИД-19 шинэ болон сэргэн тархаж буй халдвараас сэргийлэхэд салбар дундын хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ.

1.1.1. Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас сэргийлэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хариу арга хэмжээний болон нөөцийн бэлэн байдлыг хангах

1.1.2. Аймгийн нэгдсэн эмнэлэгт PCR шинжилгээ хийх орчин нөхцөл бүрдүүлэх, урвалж оношлуураар хангах

1.1.3. Бичигт хилийн боомтод тандалтын нэгж байгуулах

1.2. КОВИД-19 цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлж, бэлэн байдлыг хангахтай холбоотой төсвийн санхүүжилт, нөөц хангалтыг нэмэгдүүлнэ.

1.2.1. Гамшгийн эрсдэлийн сангийн нөөцийг нэмэгдүүлэх

1.2.2. Бараа материал, хувцас хэрэглэл, эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгал халдвартгүйтгэлийн бодис хэрэгсэл, өвс тэжээл, тоног төхөөрөмжийн нөөцийн хангалтыг нэмэгдүүлэх

1.2.3. Аймгийн төв дэх зочид буудал, сургуулийн дотуур байруудыг тусгаарлан ажиглах байр болгох, бэлтгэлийг хангаж тоог нэмэгдүүлэх

1.2.4. Тусгаарлах байранд шаардлагатай эд зүйл, хэрэгслийг бэлтгэх

ХОЁР.ХҮНИЙ ХӨГЖИЛ

2.1. Эрүүл мэнд

Өвчинеэс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж дундаж наслалтыг уртасгана.

2.1.1. Хүн амын дунд зонхилон тохиолдож буй халдварт болон халдварт бус өвчинеэс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, оношилгоо, шинжилгээний хамрагдалтыг нэмэгдүүлнэ.

2.1.1.1. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх хүрээнд халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, зөв дадал хэвшлийг бий болгоход чиглэсэн сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулах

2.1.1.2. Аймгийн Нэгдсэн эмнэлгийг түшиглэн Эрүүл мэндийг дэмжих төвийг байгуулах

2.1.1.3. Эрүүл ажлын байрыг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх

2.1.1.4. ХДХВ/ДОХ, БЗДХ, сурьеэз өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоог сум, баг, байгууллагуудын түвшинд зохион байгуулах

2.1.1.5. Артерийн даралт ихсэх, чихрийн шижин болон хөх, умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэг үзлэгийг жил бүр хийж хамрагдалтыг нэмэгдүүлэх

2.1.1.6. "Хавдрын эсрэг хамтдаа" арга хэмжээг жил бүр зохион байгуулах

2.1.1.7. Элэг бүтэн Сүхбаатар хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх

2.1.1.8. Эрэгтэйчүүдийн өвчлөл, нас баарлгад нөлөөлж буй хүчин зүйлийг судалж, Эрчүүдийн эрүүл мэндийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх

2.1.1.9. "Харшлаас сэргийлэх" арга хэмжээ зохион байгуулах

2.1.2. Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан иргэд орон нутагтаа оношлогдон, эмчилүүлэх боломжийг бүрдүүлэн, эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний төрлийг нэмэгдүүлнэ.

2.1.2.1. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт хэвлэлийн хөндийн дурангийн мэс заслын тусlamж үйлчилгээг нэвтрүүлэх

2.1.2.2. Анхан шатны эрүүл мэндийн бүх байгууллагуудад мобайл технологийг нэвтрүүлэх

2.1.2.3. Нүдний эвэрлэг болон салстын мэс заслыг орон нутагт хийх

2.1.2.4. Алслагдсан хөдөөгийн хүн амд төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч нарын явуулын амбулаторийн тусlamж үйлчилгээг үзүүлэх

2.1.2.5. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт гэмтлийн тасгийг шинээр байгуулж, тусlamж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх

2.1.2.6. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт андрологи, урологи, геронтологийн тусlamж үйлчилгээний кабинет байгуулж эмч мэргэжилтнээр хангах

2.1.2.7. Сувилахуйн тусlamж үйлчилгээ үзүүлэх жишиг сумын Эрүүл мэндийн төв байгуулж эмч, мэргэжилтнүүдийг сургаж дадлагажуулах

2.1.2.8. Баруун-Урт хотод сувилахуйн төв байгуулах төсөл хэрэгжүүлэх

2.1.3. Эх, хүүхдийн эрүүл мэндийг сайжруулах, өвчлөл, эндэгдлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлж нялхсын эндэгдлийг өмнөх 4 жилийн дундажтай харьцуулахад 1000 амьд төрөлтөд 3.4 промилиор бууруулж, эхийн эндэгдэлгүй ажиллана.

2.1.3.1. Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд, сум дундын эмнэлэгт эх, хүүхдийн өвчлөлийг бууруулах, мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангах төрөлжсөн мэргэжлийн эмч нараас бүрдсэн "Эх хүүхдийн баг"-ийг жил бүр ажиллуулах

2.1.3.2. Суурь өвчлөлтэй болон зорилтот бүлгийн хүүхдүүдийг зуны сувилалд хамруулах ажлыг зохион байгуулах

2.1.3.3. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт хүүхдийн мэдрэлийн кабинет байгуулж ЭЭГ-ээр хангах

2.1.3.4. Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн урьдчилан сэргийлэх үзлэгийг жил бүр зохион байгуулах

2.1.3.5. Жирэмсний нэрийн хяналтыг нэвтрүүлэх чиглэлээр сайн туршлага судалж хэрэгжүүлэх

2.1.3.6. Эх, хүүхдэд ээлтэй байгууллага, орон нутаг болох хөдөлгөөн өрнүүлж засаг захиргааны байгууллагын манлайллыг дэмжих

2.1.3.7. Ургийн перинаталь оношилгоог сайжруулах чиглэлээр эмч мэргэжилтнийг сургах урвалж бодис тоног төхөөрөмжөөр хангах

2.1.4. Уламжлалт анагаах ухааныг орчин үеийн анагаах ухааны ололттой хослуулан хөгжүүлж, эмчилгээний төрлийг нэмэгдүүлнэ.

2.1.4.1. Уламжлалт анагаах ухааны төвийг бие даан ажиллах нөхцөлийг бүрдүүлэн, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах

2.1.4.2. Хөдөлгөөн засалчийг бэлтгэх

2.1.4.3. Уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх хүрээнд гадаад харилцааг өргөжүүлэх

2.1.4.4. Уламжлалт эмчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх

2.1.5. Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангаж, зайлшгүй шаардлагатай эмийн хангамж хүртээмжийг нэмэгдүүлэн, бүртгэл хяналтыг тогтмолжуулна.

2.1.5.1. Эмийн чанар аюулгүй байдалд хяналт тавих, эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авах ажиллагааг орон нутагт чанартай зохион байгуулж зайлшгүй шаардлагатай эмийн хангалтыг нэмэгдүүлэх

2.1.5.2. Тусгай зөвшөөрөл бүхий эмийн сангүудад цахим жорыг нэвтрүүлж эмийн аюулгүй байдлын цахим бүртгэл хяналтыг тогтмолжуулах

2.1.5.3. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, иргэд олон нийтэд эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулах

2.1.6. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангалт, чадавхыг сайжруулан, нийгмийн хамгааллыг бэхжүүлнэ.

2.1.6.1. Орон нутгийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг гадаад улсад суралцах, туршлага судлахад дэмжлэг үзүүлэх

2.1.6.2. Эмч, эмнэлгийн ажилтан, анагаахын салбарын оюутнуудыг дэмжих, урамшуулалт олгох журам боловсруулан хэрэгжүүлэх

2.1.6.3. Эрүүл мэндийн байгууллагын ажилчдыг орон сууцаар хангах, урьдчилгаа төлбөрт хөнгөлөлт үзүүлэх, урт хугацааны зээлд хамруулах боломжийг судалж хэрэгжүүлэх

2.1.6.4. Эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийг бэлтгэх, мэргэжлийн ур чадвар, нэр хүнд, ёс зүйн хэм хэмжээг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах

2.1.7. Эрүүл мэндийн байгууллагуудын барилгын шинэчлэл, засвар үйлчилгээг хийж стандартын шаардлага хангасан барилгын хувийг 94.4 , техник тоног төхөөрөмжийн хангалтыг 85 хувьд тус тус хүргэж, яаралтай тусlamжийн автомашины парк шинэчлэл хийж 8-аар нэмэгдүүлнэ.

2.1.7.1. Өрхийн эрүүл мэндийн төвийн барилгудыг шинээр барих

2.1.7.2. Мөнххаан сумын ЭМТ-ийн барилга шинээр барих

2.1.7.3. Аймгийн Нэгдсэн эмнэлэг, Онгон сумын Сум дундын эмнэлгийн их засвар хийх

2.1.7.4. Аймгийн Нэгдсэн эмнэлгийг нүдний мэс заслын микроскоп, дурангийн мэс заслын багажаар, гэмтэл болон угаалгын тасгийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах

2.1.7.5. Аймгийн Нэгдсэн эмнэлэг, сум дундын эмнэлэг, сум, өрхийн Эрүүл мэндийн төвүүдийг нэн шаардлагатай тоног төхөөрөмжөөр үе шаттай хангах

2.1.7.6. Халзан, Уулбаян, Баяндэлгэр, Түмэнцогт, Мөнххаан, Наран, Онгон сумдыг мобайл технологиор хангах

2.1.7.7. Аймгийн нэгдсэн эмнэлгийг хүчилтөрөгчийн хийн гуравласан системд холбох

2.1.7.8. Эрүүл мэндийн байгууллагуудыг яаралтай тусlamжийн авто машинаар хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх

2.2. Биеийн тамир, спорт

Иргэдийг спортын олон төрлөөр хичээллэх боломжийг бүрдүүлж, амжилтыг ахиуна.

2.2.1. Үндэсний спортыг хөгжүүлж, өв уламжлалаар дамжуулан хүүхэд залуусыг төлөвшүүлнэ.

2.2.1.1. Аймгийн Үндэсний спортын анхдугаар наадам зохион байгуулах

2.2.2. Өсвөр үе залуучуудыг спортын олон төрлөөр хичээллэж бие бялдраа хөгжүүлэх, спортын амжилт гарах нөхцөлийг бүрдүүлнэ.

2.2.2.1. Өсвөрийн шигшээ багийг спортын 8 төрлөөр байгуулах

2.2.2.2.Стандартын шаардлага хангасан тоног төхөөрөмж, мэргэжлийн чадварлаг багш дасгалжуулагчаар хангах арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлэх

2.2.2.3. Улс, бүсийн чанартай тэмцээн уралдааныг орон нутагтаа зохион байгуулах

2.2.3. Нийтийн биеийн тамирыг бүх нийтийн хөдөлгөөн болгон өрнүүлнэ.

2.2.3.1. Стандартын шаардлага хангасан спортын цогцолбор шинээр барих

2.2.3.2. Стандартын шаардлага хангасан спортын гадаа талбайн тоог нэмэгдүүлэх

2.2.3.3. Спортын барилга байгууламжууд шинээр барих

2.2.3.4. Нийтийг хамарсан спортын эвент арга хэмжээ зохион байгуулах

2.2.3.5. Засаг даргын нэрэмжит тэмцээн, уралдаан зохион байгуулах

2.3. Боловсрол

Боловсролын үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэж, хүүхдэд ээлтэй зарчим баримталж, насан туршдаа суралцах боломжийг бүрдүүлнэ.

2.3.1. Хүүхэд бүрийн цэцэрлэгт хамрагдах боломжийг нэмэгдүүлж, чанартай боловсрол олгоно.

2.3.1.1. Наран суманд 100, Дарьганга 150, Баруун-Урт хот, Эрдэнэцагаан, Сүхбаатар, Онгон, Уулбаян суманд 200 хүүхдийн шинэ цэцэрлэг барьж, Баруун-Урт сумын 7-р цэцэрлэгийн барилгын асуудлыг шийдвэрлэх

2.3.1.2. Эрдэнэцагаан сумын 2-р , Баруун-Урт хотын 4, 9-р цэцэрлэгт их засвар хийж, Баруун-Урт хотын 5-р цэцэрлэгийг өргөтгөх

2.3.1.3. Цэцэрлэгийн хүүхдүүдийн сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгайн хангалт хийх

2.3.2. “Чадварлаг багш арга хэмжээний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж, багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжилд дэмжлэг үзүүлнэ.

2.3.2.1. "Залуу багш" хөтөлбөрийг хэрэгжүүлэх

2.3.2.2. “ДЭЛХИЙД ӨРСӨЛДӨХ СҮХБААТАРЧУУД ТӨСӨЛ, “10:10” арга хэмжээ зохион байгуулах

2.3.2.3. Шаардлагатай мэргэжлээр зөвлөх, зочин, ментор багш ажиллуулж, багш солилцоо хөтөлбөрийг хэрэгжүүлж, ахмад багш нарын зөвлөгөөн зохион байгуулах

2.3.2.4. Сурагчдын сэтгэн бодох өөрийгөө илэрхийлэх, зөв цэгцтэй ярих чадварыг хөгжүүлэх, илтгэх урлаг, мэтгэлцээний аймгийн сургагч багш нарыг бэлтгэх, энэ чиглэлээр клуб, дугуйлан хичээллүүлж , тэмцээн зохион байгуулах

2.3.2.5. Орон нутгийн түүх соёлын дурсгалыг судалж хамгаалахад багш нарын оролцоог хангаж, археологийн, болон түүх соёлын дурсгалыг таних, илрүүлэх сургалт, экспкурс аялал зохион байгуулах

2.3.2.6. Байгалийн ухааны хичээлийн сургалтын чанарыг сайжруулах, багш нарыг чадваржуулах зорилгоор Шинэ-Монгол сургуультай хамтран ажиллах

2.3.2.7. Гадаад улс оронд мэргэжил дээшлүүлэх сургалт, зөвлөгөөн, туршлага судлахад багш, боловсролын ажилтнуудад дэмжлэг үзүүлнэ.

2.3.2.8. Сумдын сургуулиуд болон Насан туршийн боловсрол төвийг мэргэжлийн багшаар хангах

2.3.2.9. Мэдээлэл зүйн багш нарын чадавхыг дээшлүүлж, боловсролын салбарын нэгдсэн системийг бий болгон, багшид шаардлагатай мэдээлэл, харилцааны технологийн тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх

2.3.3. ЕБС, цэцэрлэг, дотуур байрын хангамжийг нэмэгдүүлнэ.

2.3.3.1. Баруун-Урт хотод шинээр баригдаж байгаа 960 хүүхдийн сургуулийг ашиглалтад оруулж, 3-р сургуулийн барилгын асуудлыг шийдвэрлэх

2.3.3.2. Баруун-Урт хотын 1, 3, 4-р, Эрдэнэцагаан сумын 1-р, Халзан, Уулбаян сумын ЕБС-ийн "Б" байрны барилгад урсгал засвар хийх

2.3.3.3. Баруун-Урт хотын 2-р сургуулийн урлагийн заалны өргөтгөл, Баяндэлгэр сумын 320, Мөнххаан, Түвшинширээ сумын 240 хүүхдийн сургуулийн барилгыг өргөтгөх

2.3.3.4. Халзан, Баяндэлгэр сумдад шинэ дотуур байр барьж, Дарьганга, Мөнххаан, Түвшинширээ сумдын сургуулийн дотуур байранд их засвар хийх

2.3.3.5. Хувийн хэвшлийн сургууль, цэцэрлэг байгуулах санал, санаачилгыг дэмжих

2.3.4. ЕБС, Хүүхдийн цэцэрлэг, дотуур байрыг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгоно.

2.3.4.1. Баяндэлгэр, Мөнххаан, Дарьганга сумын сургууль, Түвшинширээ сумын хичээлийн 2-р байр, Халзан, Наран сумын ЕБС-уудыг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгох

2.3.4.2. Наран, Уулбаян, Дарьганга, Онгон болон Эрдэнэцагааны 1,2-р цэцэрлэгийг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгох

2.3.4.3. Баяндэлгэр, Түвшинширээ, Мөнхаан, Онгон, Эрдэнэцагаан, Дарьганга сумын дотуур байрыг ариун цэврийн байгууламжтай болгох

2.3.4.4. Уулбаян, Эрдэнэцагаан, Баяндэлгэр, Наран, Түвшинширээ сумдын сургуулийн дотуур байранд камержуулалт хийх

2.3.5. “Үдийн цай” арга хэмжээг “Үдийн хоол” болгож, сургууль, дотуур байр, цэцэрлэгийг шүүлтүүртэй ундны цэвэр усаар хангана.

2.3.5.1. 13 сургууль, 12 дотуур байр, 24 цэцэрлэгийг ус цэвэршүүлэгчтэй болгох

2.3.6. Сургууль, цэцэрлэгийг сургалтын хэрэглэгдэхүүн, техник, тоног төхөөрөмжөөр хангаж боловсролын чанарт ахиц гаргана.

2.3.6.1. Баруун-Урт хотын 2, 4-р сургууль, мөн хотын 6, 9, 11-р, Онгон сумын цэцэрлэгүүдэд стандартын шаардлага хангасан биеийн тамирын талбай байгуулах

2.3.6.2. ЕБС, Цэцэрлэгийг биеийн тамирын шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах

2.3.6.3. ЕБС-д лаборатори байгуулж, виртуал орчин бүрдүүлэн, дижитал технологи ашиглах боломжийг нэмэгдүүлэх

2.3.7. Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлнэ.

2.3.7.1. Төрийн албан хаагчдад монгол бичгийн сургалт явуулж, “Хүмүүн бичиг-Хүн бүрийн бичиг” нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах

2.3.7.2. Албан байгууллага, аж ахуйн нэгжүүдийн албан хэрэг хөтлөлтийг Монгол хэл, бичгээр хөтлөх бэлтгэл ажлыг хангуулах

2.3.7.3. Албан байгууллага, аж ахуйн нэгж болон нийтийн эзэмшлийн талбай, гудамжны хаягийг монгол бичгээр бичиж байрлуулах

2.3.7.4. Монгол хэл, бичгийг гадаад, дотоодод түгээн дэлгэрүүлж байгаа байгууллага, багш, сурагчдыг урамшуулах

2.3.7.5. Монгол хэлний хичээлээр анги нийтийн сургалтын чанарыг сайжруулан, массын олимпиадыг Засаг даргын ивээл дор зохион байгуулах

2.3.8. Насан туршийн боловсрол төвөөр дамжуулан олгох сургалтын чанар, хүртээмжийг сайжруулна.

2.3.8.1. Цахим сургалтын хөтөлбөр, цахим хичээл боловсруулан бүх насын иргэдэд насан туршдаа суралцах боломжийг бүрдүүлж, цахим танхим байгуулах

2.3.8.2. Зорилтот бүлгийн иргэдэд суурь боловсрол олгож, шаталсан сургалтад хамруулахад дэмжлэг үзүүлэх

2.4. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжил

Гэр бүл, хүүхэд, залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг соён гэгээрүүлж, гэр бүлийн боловсролыг дээшлүүлнэ.

2.4.1. Гэр бүлийн гишүүдийн хариуцлагыг дээшлүүлж, сургалт нөлөөллийн ажлын хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.4.1.1. Гэр бүлийг дэмжих туршилтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилтот гэр бүлд чиглэсэн үйлчилгээг өргөжүүлэх.

2.4.1.2. Байгууллагын эцэг эхийн зөвлөл шалгаруулах болзолт уралдаан зарлаж дүгнэх

2.4.1.3. "Гэр бүл , хүүхдэд ээлтэй сүм" , байгууллага шалгаруулах болзолт уралдаан зохион байгуулах

2.4.1.4. Хувь хүний ур чадварыг дээшлүүлэх сургалт зөвлөгөөн зохион байгуулах

2.4.1.5. Эмэгтэйчүүдийн уулзалт, сургалт, зөвлөгөөн, нийгэмд тустай төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулах

2.4.1.6. Гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэхэд салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах, нэгдсэн удирдлагаар хангаж, Хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах сургалт зохион байгуулж, Баруун-Урт хотын баг бүрд хамтарсан баг байгуулах.

2.4.1.7. Зорилтот өрхийн хөгжлийг дэмжих "Гэр" төсөл хэрэгжүүлэх

2.4.2. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин, нөхцөлийг бүрдүүлнэ.

2.4.2.1. Асгат, Улбаян, Түвшинширээ, Эрдэнэцагаан, Онгон сумдад ахмадын өргөө, хөгжлийн төв байгуулах

2.4.2.2. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн урлаг, спортын наадмыг зохион байгуулах

2.4.2.3. ХХҮГазрын дэргэдэх Ахмадын амралт, сувиллын үйл ажиллагааг өргөтгөх

2.4.2.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төвийг Баруун-Урт хотод байгуулах

2.4.2.5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дэд хөтөлбөр боловсруулж, хэрэгжилтийг хангах

2.4.2.6. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс, ХББЭМНХСК-ын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, тоног төхөөрөмжөөр хангах

2.4.3. Залуучуудын хөгжлийг дэмжинэ.

2.4.3.1. Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дэргэдэх залуучуудын хөгжлийн төвийг 1 цэгийн үйлчилгээ үзүүлэх төв болгон, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангаж, тохижуулах

2.4.3.2. "Нутгийн Залуучууд" хөтөлбөр хэрэгжүүлж, залуучуудын чуулган зохион байгуулах

2.4.4.Хүүхдийн хөгжил хамгааллын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.4.4.1. ГБХЗХГ-ын гадна фасад, барилгын их засвар хийх

2.4.4.2. Хүүхдийн оролцоо үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хангах хүрээнд "Хүүхдийн чуулган" зохион байгуулж, гарсан шийдвэр, санал санаачилгын хэрэгжилтийг хангах

2.4.4.3. "Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээ"-г салбар дундын хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулах

2.4.4.4. Хэрэг зөрчилд холбогдсон, хохирсон хүүхдүүдэд "Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо"-оор дамжуулан үйлчилгээ үзүүлж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулах

2.4.4.5. Хүүхэд хамгааллын турниket системийг Баруун-Урт хотын Ерөнхий боловсролын сургуульд нэвтрүүлэх

2.4.4.6. Хүүхэд, залуучуудын хөдөлмөр зуслан, эко зуслан байгуулах

2.4.4.7. Хурдан морины уралдаанч хүүхдийн хамгаалалтын хувцас, морины хэрэгсэлд тавих шаардлага MNS6264:2018 стандартын хэрэгжилтийг ханган, уралдаанч хүүхдүүдийн уулзалт зөвлөгөөн , хэлэлцүүлэг зохион байгуулах

2.4.4.8. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ганцаарчилсан сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх танхим байгуулах

2.5. Хөдөлмөр, нийгмийн хамгаалал

Нийгмийн халамжийн үйлчилгээг оновчтой болгон, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, өрхийн амьжиргааны түвшнийг дээшлүүлнэ.

2.5.1. Хувийн хэвшил, жижиг, дунд үйлдвэрлэл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, шинэ ажлын байр бий болгоно.

2.5.1.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах

2.5.1.2. "Малчны залуу халаа" хөтөлбөрийг шинээр хэрэгжүүлэх

2.5.1.3. Гарааны бизнес буюу старт-аппыг дэмжиж, хөгжүүлэн ажлын байрыг бий болгох

2.5.1.4. Орон нутгийн хэрэгцээнд тулгуурласан мэргэжилтэй ажилтан бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх арга хэмжээг зохион байгуулах

2.5.1.5. Иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах

2.5.1.6. Ажлын байрыг бий болгох, хадгалахад чиглэсэн хөнгөлөлттэй зээлийг иргэд , аж ахуйн нэгжид олгох

2.5.2. Орон нутгийн хөгжлийн зорилттой уялдуулан мэргэжлийн боловсрол, сургалтыг төрөлжүүлж хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлнэ

2.5.2.1. Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн зах зээлийн судалгааг аймгийн хэмжээнд зохион байгуулах

2.5.2.2. Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн багш нарыг мэргэшүүлэх, туршилага судлуулах арга хэмжээг зохион байгуулах

2.5.2.3. "Ажилтай төгсөгч" хөтөлбөрийг хэрэгжүүлж, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх

2.5.2.4. Хөдөлмөрийн зах зээлийн төлөвтэй уялдуулан мэргэжлийн ангийн чиглэлийг оновчтой болгох

2.5.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчин, нөхцөлийг сайжруулна.

2.5.3.1. Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн 3 талт хэлэлцээрийг 2 жил тутам зохион байгуулж, хэрэгжилтийг хангах

2.5.3.2. ХАБЭА-н орчин бүрдүүлсэн ААН-ийг урамшуулах

2.5.3.3. Цалин хөлс, ХАБЭА-н талаарх Засаг даргын нэрэмжит сарын аян, зөвлөн туслах арга хэмжээг зохион байгуулах

2.5.4. Нийгмийн халамжийн үйлчилгээг цахимжуулж иргэдэд үзүүлэх үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй олгоно.

2.5.4.1. Нийгмийн халамжийн үйлчилгээг цахимжуулах ажлыг үе шаттай зохион байгуулах

2.5.5. Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлж аймгийн хэмжээнд татварт бүртгэлтэй ажил олгогчийн 98, эдийн засгийн идэвхтэй хүн амын 50 хувийг нийгмийн даатгалд, нийт хүн амын 98 хувийг эрүүл мэндийн даатгалд хамруулна.

2.5.5.1. Нийгмийн даатгалын тухай хууль болон бусад холбогдох хууль тэдгээрийг дагалдан гарах журам, дүрмийг иргэдэд сурталчлах, сургалт сурталчилгааг сайжруулах

2.5.5.2. Цахим үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх

2.5.5.3. Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тэтгэврийн даатгалын нөхөн шимтгэл төлөлтийг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх

2.5.6. Өрхийн амьжиргааны түвшнийг дээшлүүлэх арга хэмжээг хөдөлмөр эрхлэлтийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлнэ.

2.5.6.1. Зорилтот өрхийн хөгжлийг хамгааллыг сайжруулах дэд хөтөлбөрийн хүрээнд өрхийн амьжиргаанд дэмжлэг үзүүлэх

2.5.6.2. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамруулах

2.5.7. Жөндэрийн эрх тэгш байдлыг хангах арга хэмжээг хэрэгжүүлж, нөлөөллийн ажлын нэр төрлийг нэмэгдүүлнэ.

2.5.7.1. Жөндэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн сургалт, сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах

2.5.7.2. Жөндэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах

2.6. Үндэсний бахархал, өв соёл

Үндэсний нэгдмэл бахархлыг сэргээж, эх хэл, түүх, өв соёлоо дээдэлсэн эх оронч үзэл, эв нэгдлийг эрхэмлэсэн иргэнийг хөгжүүлж, нийгмийг соён гэгээрүүлнэ.

2.6.1. Үндэсний үнэт зүйлсийг хадгалж хамгаалан хойч үедээ өвлүүлэн уламжилна.

2.6.1.1. Үл хөдлөх дурсгалуудыг хамгаалах, хүн чулууны хадгалалт, хамгаалалтыг сайжруулах

2.6.1.2. Соёлын биет бус өв тээгчдийн судалгааг бодитой болгон, өвлөн уламжлуулах арга хэмжээг зохион байгуулж, алдаршуулах

2.6.2. Хүүхэд залуусыг үндэсний өв соёл, ёс заншлаа дээдлэгч, өвлүүлэгч, хамгаалагч иргэн болгож хөгжүүлнэ.

2.6.2.1. Угсаатны зүйн музейн стандартын шаардлага хангасан барилга барих

2.6.2.2. Орон нутгийн угсаатны зүйн музейн үзмэрийг хүүхэд бүрд үзүүлэх арга хэмжээг зохион байгуулах

2.6.3. Угсаатны өв соёл, ёс заншлыг түгээн дэлгэрүүлнэ.

2.6.3.1. "Өв соёл" -ын эвент арга хэмжээнүүд зохион байгуулах

2.6.3.2. "Дарьганга соёлын өв", "Сүхбаатар аймаг" брэнд брэндбүүк бүтээн, соёл урлагийн болон сурталчилгааны контент шинээр бий болгож, олон нийтэд сурталчлах, сувгийн хөгжүүлэлт хийх

2.6.4. Аймгийн хэмжээнд нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж, угийн бичиг хөтлөх уламжлалыг сэргээнэ.

2.6.4.1. Угийн бичиг хөтлөх арга хэмжээг бүх нийтийн хөдөлгөөн болгон өрнүүлэх

2.6.5. Соёл, урлагийн байгууллагын чадавхыг сайжруулна.

2.6.5.1. Баяндэлгэр, Түмэнцогт, Онгон сумдад стандартын шаардлага хангасан Соёлын төв барих

2.6.5.2. Соёлын төвүүдийг техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангаж, алслагдсан хөдөөгийн иргэдэд соёлын явуулын үйлчилгээг хүргэх

2.6.5.3. "Жаахан шарга" театрны акустик, галерей, тайзны болон хөгжмийн зэмсэгт шинэчлэл хийх

2.6.5.4. Виртуал технологид сууриссан соёлын өвийн танилцуулга, цахим музейтэй болоход шаардлагатай тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх

2.6.6. Номын сангийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.6.6.1. Орчин үеийн, стандартын шаардлага хангасан Нийтийн номын сангийн байр барих

2.6.6.2. Сумдын номын сангуудыг номын сангийн LIB4U нэгдсэн программд холбох

ГУРАВ.ЭДИЙН ЗАСАГ

3.1. Санхүү, төсвийн зохицуулалт

Аймгийн төсвийн орлого, санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, төсвийн хөрөнгийг эдийн засаг, нийгмийн хөгжилд чиглүүлж, үр ашигтай, хариуцлагатай зарцуулна.

3.1.1. Орон нутгийн өмчтэй болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд сайн засаглалыг хөгжүүлэх замаар өмчийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.

3.1.1.1. Удирдлагын багийг чадавхжуулах замаар үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн үр ашигтай ажиллах боломжийг бүрдүүлэх

3.1.1.2. Санхүүгийн сахилга, хөрөнгийн ашиглалтыг сайжруулснаар алдагдлыг бууруулах

3.1.2. Төсвийн төлөвлөлтийг боловсронгуй болгож сахилга хариуцлагыг сайжруулах замаар үр ашгийг нэмэгдүүлнэ.

3.1.2.1. Татварын тайлрагналт, хураалтын үйл ажиллагааг цахимжуулж, ил тод байдлыг нэмэгдүүлэх замаар татварын үйлчилгээг иргэд, татвар төлөгчдөд хүндрэлгүй болгох

3.1.2.2. Төсөв, санхүүгийн цахим систем нэвтрүүлж, төрийн үйлчилгээг шуурхай, үр ашигтай болгон төсвийн урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг ил тод, хэмнэлттэй зарцуулах нөхцөлийг бүрдүүлэх

3.1.2.3. Газар, үл хөдлөх эд хөрөнгө, авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн бүртгэлийг сайжруулж, татварын хувь хэмжээг бууруулах замаар татварт хамрагдалтыг нэмэгдүүлэх

3.1.2.4. Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжиж, тогтвортой нэмэгдүүлэх

3.1.3. Банкнаас бусад олон талт санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

3.1.3.1. Иргэн, хуулийн этгээдийн хөрөнгийн болон бусад үүсмэл санхүүгийн зах зээлийн талаарх мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх

3.1.3.2. Даатгалын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх

3.1.4. Статистик мэдээллийн хамрах хүрээ, тооллого, судалгааны үр өгөөжийг нэмэгдүүлнэ.

3.1.4.1. Улсын хэмжээний тооллого, судалгааг зохион байгуулах

3.1.4.2. Статистикийн анхан шатны мэдээ, тайлангийн чанарт анхаарч сумд, ААНБ-д улсын байцаагч нарын хяналт, шалгалтыг хийх

3.2. Уул уурхай, хүнд үйлдвэр

Ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх замаар орон нутгийн хөгжилд оруулах хувь нэмэр, үр өгөөжийг нэмэгдүүлнэ.

3.2.1. Ашигт малтмал, газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулна.

3.2.1.1. Байгаль, орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил арга хэмжээг, чанартай гүйцэтгүүлж, байгаль орчинд эзлтэй дэвшилтэй техник, технологи нэвтрүүлж байгаа аж ахуй нэгжийн үйл ажиллагааг дэмжин ажиллах

3.2.1.2. Уул уурхайн ашиглалт, тээвэрлэлтийн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилтыг бууруулах, байгаль орчин, экосистемийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор бүтээгдэхүүн тээвэрлэлтийн экспортын хүнд даацын авто зам барих ажлыг үе шаттай хэрэгжүүлэх

3.2.1.3. Орон нутгийн дэд бүтэц, бүтээн байгуулалтын ажилд шаардагдах ТТАМ-ын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох, тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхэд орон нутгаас санал санаачилга гарган ажиллах

3.2.2. Уул уурхай, газрын тосны салбарын үйл ажиллагаанаас орон нутгийн хөгжил, иргэдэд үзүүлэх үр өгөөжийг нэмэгдүүлнэ.

3.2.2.1. Уурхайг ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах, ажлын байр нэмэгдүүлэх, орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нартай нутгийн захиргааны байгууллага хамтран ажиллах гэрээ байгуулж ажиллах

3.2.2.2. Уул уурхайн салбарын хууль, тогтоомжийг сурталчлан таниулах, тусгай зөвшөөрөл, үйл ажиллагааны талаарх мэдээллийг орон нутгийн иргэдэд мэдээлэх

3.2.2.3. Төрийн захиргааны төв байгууллага, агентлаг, уул уурхайн компаниуд болон орон нутгийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах зорилгоор салбарын зөвлөгөөн, уулзалтыг зохион байгуулах

3.2.2.4. Аймгийн хэмжээнд уул уурхайн салбарын хайгуул, ашиглалтын хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох, хяналт шалгалт явуулж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах

3.2.3. Уул уурхайн орд газрыг түшиглэн экспортод чиглэсэн хүнд үйлдвэр байгуулах санал санаачилгыг дэмжинэ.

3.2.3.1. Хөөт, Ерөөлт, Цахиурт овоогийн уурхайн ордыг түшиглэн хүнд үйлдвэр байгуулах төслүүдийн үйл ажиллагааг орон нутгаас бодлогоор дэмжин хамтран ажиллах

3.3. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг өргөжүүлэн, малын эрүүл мэндийг хамгаалж, малын ашиг шимийг дээшлүүлнэ.

3.3.1. Атрын IV аяныг хэрэгжүүлж, атаршсан газрын талбайн ашиглалтыг сайжруулан, тариалалтыг нэмэгдүүлнэ.

3.3.1.1. Үр тарианы аж ахуй нэгжүүдийн талбайн ашиглалтыг сайжруулах

3.3.1.2. Төмс, хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлж, дотоодын хэрэгцээний 40-өөс доошгүй хувийг хангах

3.3.1.3. Тариалангийн талбайг мал, тэжээвэр амьтны хөлөөс хамгаалах ажлыг эрчимжүүлэх

3.3.2. Малын эрдэс, тэжээлийн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.

3.3.2.1. Малын тэжээлийн тариалалтыг нэмэгдүүлэх

3.3.2.2. Орон нутагт эрдэс тэжээлийн цех байгуулах санал санаачилгыг дэмжих

3.3.3. Өвөл зуны хүлэмжийн болон зоорины аж ахуйг хөгжүүлж, хүнсний ногооны ургацыг нэмэгдүүлнэ.

3.3.3.1. Өвлийн хүлэмжийн аж ахуйг шинээр байгуулах

3.3.3.2. Нийлэг хальсан хүлэмжийн аж ахуйг нэмэгдүүлэх

3.3.3.3. “Жимс, жимсгэнэ” үндэсний, хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж, жимс, жимсгэнийн суулгац үржүүлгийн төвийн хамгаалалтыг сайжруулах

3.3.3.4. Зоорины аж ахуйн ашиглалтыг сайжруулж, иргэдэд чанартай хүнсний ногоо нийлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх

3.3.4. Аймгийн хүн амын гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг орон нутгийн үйлдвэрлэлээр бүрэн хангах, хүнсний аюулгүй байдалд тавих хяналтыг сайжруулна.

3.3.4.1. Хүн амын стратегийн болон гамшгийн үеийн хүнсний нөөц бүрдүүлэх ажлыг аймаг, орон нутгийн хэмжээнд зохион байгуулах

3.3.4.2. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх

3.3.4.3. Хүнсний үйлдвэр, нийтийн хоолны аюулгүй байдалд хяналт тавьж эрсдэлийг бууруулах

3.3.5. Бэлчээрийг усжуулах, худагжуулах ажлыг үргэлжлүүлэн малын бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлэх, хамгаалах, нөхөн сэргээнэ.

3.3.5.1. Бэлчээрт ашиглаж байгаа худаг, уст цэгийн тооллогыг явуулж байршил, ашиглалт, эзэмшигчийг тодорхойлж бүртгэл, мэдээллийн нэгдсэн сантай болох

3.3.5.2. Бэлчээрт шинээр гүний худаг гаргах

3.3.5.3. Бэлчээрийн мэрэгч үлийн цагаан оготнотой тэмцэх арга хэмжээг зохион байгуулах

3.3.5.4. Сум дундын болон сумын отрын бүс нутгийг тогтоох, хил заагийг тодорхойлж баталгаажуулах

3.3.5.5. Малчдын бүлгийн оролцоонд тулгуурлан бэлчээр нутгийн тогтвортой ашиглалтыг хангаж, доройтсон бэлчээрийг сэргээх арга хэмжээ хэрэгжүүлэх

3.3.5.6. Сумдад өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг хадгалах агуулах, саравч шинээр барих ажлыг үргэлжлүүлэх

3.3.5.7. Сумын аюулгүйн нөөцийг бие даан бэлтгэх хүрээнд зарим сумдад хадлан бэлтгэлийн техник, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх

3.3.6. Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгж байгуулах, хээлтүүлэгч болон цөм сүргийг мэргэжлийн байгууллагын хяналтад авах, генетик нөөцийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, нэгжийн ашиг шимийг дээшлүүлнэ.

3.3.6.1. Жил бүр үржлийн малын 1-ээс доошгүй хувьд үзлэг ангилалт тогтмол хийж, ээмэгжүүлэн, бүртгэл мэдээллийн санд оруулах

3.3.6.2. Хавар, намар малд хийх үзлэг ангилалтад хяналт тавьж, үр дүнг тооцох

3.3.6.3. Сумдад мал бордох цогцолбор байгуулах

3.3.6.4. Бог малын хээлтүүлэгчийг үзлэг ангилалтад бүрэн хамруулж анги чанарыг тодорхойлох ажлыг зохион байгуулах

3.3.6.5. Бог малын хээлтүүлэгчийг бүрэн ээмэгжүүлж, мэдээллийг бүртгэл мэдээллийн нэгдсэн санд оруулах

3.3.6.6. Мал үржүүлэг технологийн нэгж болон шинээр байгуулагдсан аж ахуйн нэгжүүдийг үйл ажиллагаагаа эхлүүлэхэд нь нэг удаагийн дэмжлэг үзүүлэх

3.3.6.7. Сумдын ХАА-н тасгийн малын бүртгэл мэдээлэл хариуцсан мэргэжилтнийг бүртгэл мэдээллийн нэгдсэн сан үүсгэх боломж бүхий компьютер, тоног төхөөрөмжөөр хангах

3.3.7. **Өндөр ашиг шимт мах, сүүний чиглэлийн үүлдрийн үхэр, гахай, шувууны эрчимжсэн аж ахуйг хөгжүүлж, ашиг шимиийг нь нэмэгдүүлнэ.**

3.3.7.1. Цэвэр үүлдрийн болон эрлийз, цус сайжирсан малын тоог нэмэгдүүлэн гадаадын өндөр ашиг шимт эцэг малын гүн хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлэг хийх

3.3.7.2. Гойд ашиг шимт малын үзэсгэлэн худалдааг жил бүр зохион байгуулах

3.3.7.3. Эрчимжсэн аж ахуй эрхлэгчийг дэмжих

3.3.7.4. Үйлдвэр технологийн паркийн үйл ажиллагааг өргөтгөж, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн боловсруулах төв байгуулах

3.3.8. **Малын гоц халдварт, халдварт, зоонози, халдвартгүй өвчнөөс урьдчилан сэргийлж, малын өвчнөөр тайван бүсийг тогтооно.**

3.3.8.1. Үхрийн цээж, ямааны годрон өвчнөөр тайван байдлыг баталгаажуулах

3.3.8.2. Халдварт зоонози өвчний гаралтыг багасган уг өвчнөөр тайван, халдвартгүй бүсээр баталгаажуулах

3.3.8.3. Эрсдэлт бүс нутгийн өвчлөмтгий мал сүргийг гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинд бүрэн хамруулах

3.3.8.4. Шимэгчтэх өвчний халдварталтыг бууруулах

3.3.8.5. Бэлчээрийн эрүүл ахуйг сайжруулах хүрээнд ариутгал, халдвартгүйтгэл хийх

3.3.9. **Мал эмнэлгийн лабораторийн орчин нөхцөлийг сайжруулж, хувийн хэвшлийн мал эмнэлгүүдэд стандарт мөрдүүлнэ.**

3.3.9.1. Мал эмнэлгийн газрын барилгад их засвар хийж, лабораторийг техник, тоног төхөөрөмжөөр хангах ажлыг үе шаттай хэрэгжүүлэх

3.3.9.2. Сум дундын мал эмнэлэг, ариун цэврийн анхан шатны лаборатори байгуулах

3.3.9.3. Цахим системийн ашиглалтыг чанаржуулж, мал эмнэлгийн бүх ажил үйлчилгээг нэгдсэн системд оруулах

3.3.10. Шинэ технологи, инновацын ололтод суурилсан эдийн засгийн үр ашигтай орон нутгийн эко бизнес, хөнгөн үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээг хөгжүүлнэ.

3.3.10.1. Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарын бүтээгдэхүүн үйлчилгээг орон нутаг, улс, олон улсын түвшинд сурталчлан таниулах зорилготой цахим катологийг ашиглалтад оруулах

3.3.10.2. Хөнгөн үйлдвэр эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг борлуулах гадаад, дотоодын зах зээлийг өргөтгөх ажлыг зохион байгуулах

3.3.11. Оюуны өмчийн патент, чанар стандартын баталгаатай орон нутгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний тоог нэмэгдүүлнэ.

3.3.11.1. Бүтээгдэхүүн, үйлчилгээний оюуны өмчийн патент, чанар стандартыг нэмэгдүүлэх зорилгоор мэргэжлийн байгууллагын зөвлөн туслах үйлчилгээг бизнес эрхлэгчдэд хүргэх ажлыг зохион байгуулах

3.3.11.2. Олон улсын стандарт нэвтрүүлэх ажлыг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах

3.3.11.3. Орон нутгийн бүтээгдэхүүний тохирлын баталгаажуулалтыг нэмэгдүүлж, холбогдох төрийн байгууллагуудтай хамтарч сургалт зохион байгуулах

3.3.11.4. Үйлчилгээний байгууллагын стандартын түвшнийг ахиулах зорилгоор 2 жилд нэг удаа мэргэжлийн байгууллагуудын хамтарсан аттестатчиллын шалгалтыг үе шаттайгаар зохион байгуулах

3.3.12. Экспортын баримжаатай үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.

Экспортын гэрчилгээтэй бүтээгдэхүүний тоог нэмэгдүүлж, стандартын бодлогоор дэмжих ажлыг зохион байгуулах

3.3.13. Жижиг, дунд үйлдвэр, бизнес эрхлэгчдэд олгосон санхүүжилтийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.

3.3.13.1. Сум хөгжүүлэх сан, ЖДУ сан, Төсөл хөтөлбөрийн хүрээн дэх хөнгөлөлттэй зээл олголтыг орон нутгийн үйлдвэрлэлийн бодлоготой уялдуулан олгож, ажлын байрыг нэмэгдүүлэх

3.3.13.1. Max, ноос ноолуур, арьс шир боловсруулах үйлдвэр байгуулах аж ахуй нэгжийн санаачилгыг хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр дэмжих

3.3.14. Махны үйлдвэр, хорио цээрийн бүс бүхий цогцолбор байгууламж барих төслийн хүрээнд ХАА-н түүхий эд боловсруулах төвийг байгуулна.

3.3.14.1. Төслийг орон нутагт хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах

3.3.15. Бизнес эрхлэгчдэд бүх төрлийн дэмжлэг, туслалцааг үзүүлэх бизнес инкубаторын үйлчилгээг нэвтрүүлнэ.

3.3.15.1. "Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх" аймгийн дэд хөтөлбөрийг батлан хэрэгжүүлэх

3.3.15.2. Орон нутгийн брэнд бүтээгдэхүүнийг бий болгох, хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх

3.3.15.3. Бизнес эрхлэгчдийн бүтээгдэхүүн, үйлчилгээг өргөтгөх, харилцан туршлага солилцох зорилгоор гадаад, дотоодын үзэсгэлэн худалдаа, туршлага судлах аялал, бусад арга хэмжээнд дэмжин оролцуулах

3.3.15.4. Сүхбаатар хөгжил арга хэмжээний хүрээнд "Эрүүл хүнс", "Алтан намар", "Сүхбаатарт үйлдвэрлэв" үзэсгэлэн худалдааг жил бүр зохион байгуулах

3.3.15.5. Бизнес эрхлэгчдэд инкубаторын үйлчилгээ үзүүлэх

3.3.16. Орон нутгийн бизнес эрхлэгч иргэн, аж ахуй нэгж, хоршоодын бэлтгэн нийлүүлэлт, үйлдвэрлэл, борлуулалтын тогтолцоог кластерын системээр хөгжүүлнэ.

3.3.16.1. Хоршоодоор дамжуулан хөдөө аж ахуйн түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийг хийж, аймгийн хэмжээнд хоршоодыг хөгжүүлэх ажлыг зохион байгуулах

3.3.16.2. Загвар хоршоо байгуулах

3.3.17. Бизнесийн салбарын техник туслалцааны зөвлөх үйлчилгээг нэмэгдүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.

3.3.17.1. Бизнес эрхлэгчдийн бүтээгдэхүүн үйлчилгээг чанаржуулах, бизнес төсөл боловсруулах чадварыг дээшлүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах хүрээнд гадаад, дотоодын төсөл хөтөлбөр, их дээд сургууль, мэргэжлийн байгууллагуудтай хамтран техник туслалцааны ажлыг нэвтрүүлэх

3.3.18. Бизнес эрхлэгчдэд таатай орчин бүрдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлнэ.

3.3.18.1. ТХХЗөвлөлийн үйл ажиллагааг өргөжүүлэн хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх

3.4. Аялал жуулчлал

Аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээ, чанар стандартыг сайжруулж, байгаль орчинд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

3.4.1. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг сайжруулна.

3.4.1.1. Аймгийн аялал жуулчлалын нөөц, даацын судалгааг хийх

3.4.1.2. Аймгийн аялал жуулчлалын салбарын хөгжлийн дунд хугацааны стратегийг боловсруулан, хэрэгжүүлэх

3.4.1.3. Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ААНБ-д зөвлөх үйлчилгээний сургалт зохион байгуулж, стандартын түвшнийг нэмэгдүүлэх

3.4.1.4. Аялал жуулчлалын гол чиглэлийн дагуу стандартад нийцсэн түр буудаллах цэг байгуулах

3.4.1.5. Аялал жуулчлалын бус бүрд нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлж, нүүдлийн соёл иргэншлийг харуулсан морь, тэмээн аялал, шувуу ажиглах, язгуур урлаг, өв соёлын арга хэмжээ зохион байгуулах

3.4.1.6. Хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх гадаад жуулчдын урсгалыг нэмэгдүүлэх

3.4.1.7. Эрдэнэцагаан суман дахь 80 ортой зочид буудлыг бүрэн ашиглалтад оруулж, үйл ажиллагааг тогтмолжуулах

3.4.2. Аялал жуулчлалын маркетинг сурталчилгааг өргөжүүлнэ.

3.4.2.1. Үйлчилгээний байгууллага, иргэдэд аялал жуулчлалын менежментийн талаар боловсрол олгох, тэдний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих, үзэсгэлэнд оролцуулах

3.4.2.2. Аймгийн аялал жуулчлалыг сурталчилсан ном товхимол хэвлүүлж, бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах

3.4.2.3. Аялал жуулчлалын холбооны үйл ажиллагааг эрчимжүүлэх

3.4.2.4. Орон нутгийн өв соёлыг сурталчлан таниулах эвент арга хэмжээг зохион байгуулж, тогтмолжуулах

3.4.3. Аялал жуулчлалын бүс нутаг дахь орчны бохирдлыг бууруулна.

3.4.3.1. Аялал жуулчлалын бүс нутагт эко ариун цэврийн байгууламж /00/ байгуулах

3.4.3.2. Хог хаягдлыг бууруулах чиглэлээр мэдээллийн самбар байршуулж, нөлөөллийн ажил хийх

3.5. Тээвэр, логистик

Эдийн засгийн өсөлтийг хангахуйц, ухаалаг системд суурилсан тээвэр, логистикийн сүлжээг байгуулна.

3.5.1. Баруун-Урт-Бичигт чиглэлийн 272 км хатуу хучилттай хүнд даацын авто зам барина.

3.5.1.1. Баруун-Урт-Бичигт чиглэлийн 272 км хатуу хучилттай хүнд даацын авто зам барих ажилд орон нутгаас дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах

3.5.2. Дорноговь аймгийн Сайншанд-Баруун-Урт-Хөөт чиглэлийн 433 км төмөр замын төслийг эхлүүлнэ.

3.5.2.1. Сайншанд-Баруун-Урт-Хөөт чиглэлийн 433 км төмөр замын төслийг эхлүүлэхэд орон нутгаас дэмжлэг үзүүлж, санал санаачилга гарган хамтран ажиллах

3.5.3. Олон улсын тээвэр логистикийн төв байгуулна.

3.5.3.1. Бичигт боомт хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулан тээвэр логистикийн төв байгуулах ажлыг эхлүүлэх

3.6. Барилга, хот байгуулалт

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын бодлогыг хот төлөвлөлттэй уялдуулж, иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.

3.6.1. Аймгийн төвийн болон сумдын үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлцуулах шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

3.6.1.1. Баруун-Урт хотын үерийн ус зайлцуулах далан сувгийг барих

3.6.1.2. Эрдэнэцагаан, Наран суманд үерийн ус зайлцуулах далан сувгийг барих

3.6.2. Гэр хорооллыг дахин төлөвлөх замаар орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.

3.6.2.1. Баруун-Урт хотын 3-р тойргоос дотогш дахин төлөвлөлт хийж, шинэ суурьшлын бүсийн бүтээн байгуулалтын ажлыг үе шаттай хэрэгжүүлэх, барилгажуулах

3.6.2.2. Сумдад гэр хорооллын газрыг шинэчлэн зохион байгуулж, орон сууц барих

3.6.2.3. Төр хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан орон сууцны барилга, хотхон, хороолол барих ажлыг сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн үе шаттай хэрэгжүүлэх

3.6.2.4. Түрээсийн орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлэх

3.6.2.5. Боловсрол хорооллын доторх тохижилтын ажлыг төлөвлөлтийн дагуу хэрэгжүүлж дуусгах

3.6.3. Гэр хорооллыг төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбоно.

3.6.3.1. Баруун-Урт хотын Хайлааст гэр хорооллыг цэвэр ус, дулаан, холбоо хангамж, ариутгах татуургын шугамд холбох

3.6.3.2. Баруун-Урт хотын гэр хорооллын айл өрхийг хэсэгчлэн дулаан хангамжид холбох

3.6.3.3. Сумдад хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдсан инженерийн шугам сүлжээний өргөтгөл хийх

3.6.4. Орон нутгийн барилгын материалын үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

3.6.4.1. Барилгын материалын лабораторийн барилгыг ашиглалтад оруулах

3.6.4.2. Барилгын салбарт эрчим хүчний хэмнэлттэй, ногоон бүтээгдэхүүн үйлдвэрлэгч дотоодын үйлдвэрлэлийг дэмжих

3.6.4.3. Барилгын хатуу хог хаягдлыг байгаль орчинд халгүй аргаар устгах, дахин боловсруулах үйлдвэрлэлийг дэмжин ажиллах

3.6.4.4. Хайрганы карьер, ханын дүүргэгч хөнгөн блок, барилгын бетон хийц, асфальт бетон, хавтгай шилний үйлдвэр барих санал санаачилгыг дэмжих

3.6.5. Аймгийн хэмжээнд хаягжилтын нэгдсэн системийг бүрдүүлнэ.

3.6.5.1. Барилга байгууламж, үл хөдлөх хөрөнгө, гудамж зам талбайг хаягжуулах

3.6.5.2. Аймаг, сумын төвийн хаягжуулалтын ажлыг стандартын дагуу хэрэгжүүлж, төлөвлөлтийн дагуу эгнээ гудамжны эмх цэгцийг сайжруулах ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулах

3.6.6. Газар өмчлөлийг эрчимжүүлнэ.

3.6.6.1. Дэд бүтцийн хангамжид тулгуурлан иргэнд газар өмчлүүлэх боломжтой газрын нөөцийг тогтоож газрыг өмчлүүлэх

3.6.7. Нийт нутаг дэвсгэрийг бүх төрлийн масштабын байр зүйн зурагтай болгоно.

3.6.7.1. Баруун-Урт хот, Эрдэнэцагаан, Дарьганга, Онгон, Мөнххаан сумд, Бичигт боомтын 1:100 000-ны байр зүйн зургийг боловсруулах

3.6.7.2. Газар зүйн нэрийн тодруулалтыг хийх

3.6.8. Барилгуудыг паспортжуулалт, гэрчилгээжүүлэх ажлыг эрчимжүүлж иргэдийн аюулгүй ажиллах амьдрах баталгааг хангана.

3.6.8.1. Төрийн болон орон нутгийн өмчийн барилгуудыг паспортжуулах, гэрчилгээжүүлэх

3.6.8.2. Хувийн хэвшлийн барилгуудыг паспортжуулах, гэрчилгээжүүлэх

3.6.9. Барилгын газар хөдлөлтөд тэсвэрлэлтийг тогтоож, чанарыг дээшлүүлнэ.

3.6.9.1. Төрийн болон орон нутгийн өмчийн барилгуудын газар хөдлөлтөд тэсвэрлэх чанарыг тогтоох

3.6.9.2. Нийтийн орон сууцуудын газар хөдлөлтөд тэсвэрлэх байдлыг тогтоож, төлөвлөлт хийх

3.6.9.3. Газар хөдлөлтийн байнгын ажиллагаатай зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлж ажиллах

3.6.10. Сум, суурин газрын төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулна.

3.6.10.1. Халzan, Мөнххаан, Сүхбаатар, Асгат, Онгон, Наран, Уулбаян, Баяндэлгэр сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж батлуулах

3.6.10.2. Аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг тодотгох ажлыг хэрэгжүүлэх

3.6.10.3. Онгон, Мөнххаан, Уулбаян, Түмэнцогт, Наран, Асгат, Халzan сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж батлуулах ажлыг зохион байгуулах

3.6.11. Аймаг, сумдын төвийн хүн амыг эрүүл ахуй, стандартын шаардлага хангасан ундны усаар хангана.

3.6.11.1. Баруун-Урт хотын хүн амын ундны ус цэвэршүүлэх тоног төхөөрөмжийн технологийн шинэчлэлтийг хийж хэвийн ажиллагааг хангах

3.6.11.2. 1000м3, 2000м3 усан сан, өргөлтийн насос станц №3, №5-ын битүүмжийг сайжруулж, шугам сүлжээг шинэчлэн, усны алдагдлыг бууруулах

3.6.11.3. Цэвэр усны өргөлтийн насос станц №3-ын хүчин чадлыг нэмэгдүүлэх

3.6.11.4. Цэвэр усны хайгуул хийж, гүний худгийн тоог нэмэгдүүлэх

3.6.11.5. Ундны усны эх үүсвэрийн гүний худгуудыг хашаажуулах

3.6.11.6. Төвлөрсөн цэвэр ус түгээлтийн шугам сүлжээг дулаан дамжуулах төвтэй холбох ажлыг хийх

3.6.11.7. Зөөврийн ус түгээх цэгүүдийг төвлөрсөн шугамд холбох

3.6.11.8. Баруун-Урт хотын нийтийн хуучин орон сууцуудын дундын өмчлөлийн цэвэр, бохир усны шугам сүлжээг шинэчлэх

3.6.11.9. Сумдын төвийн хүн амын ундны усанд таарсан технологи сонгох техникийн шийдлийг гаргах

3.6.11.10. Сумдын төвийн хүн амын ундны усны эх үүсвэрт цэвэршүүлэх төхөөрөмж тавих

3.6.11.11. Аймгийн Усны аюулгүй байдлын төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх

ДӨРӨВ. ЗАСАГЛАЛ

"Иргэн төвтэй хариуцлагатай төрийн албыг бэхжүүлж, ногоон технологи бүхий сайн засаглалыг хөгжүүлнэ.

4.1. "Цахим Сүхбаатар"-төрийн шуурхай үйлчилгээ

4.1.1. Аймгийн хэмжээнд удирдлагын мэдээллийн нэгдсэн цахим программыг нэвтрүүлнэ.

4.1.1.1. Sukhbaatar.mn болон сумдын вэб сайтыг шинэчлэн, төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системийг нэвтрүүлэх

4.1.1.2. Төрийн мэдээллийг олон нийтэд нээлттэй, хүртээмжтэй мэдээлэх зорилгоор орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах

4.1.1.3. Төрийн архивд хадгалагдаж байгаа сан хөмрөгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулж стандартын шаардлага хангасан тавиур, шүүгээ, тоног төхөөрөмжөөр хангах

4.1.1.4. Төрийн архивд хадгалагдаж байгаа баримтуудыг цахимд шилжүүлэх ажлыг зохион байгуулах

4.1.2. Төрийн байгууллагын ажиллах нөхцөл, техник технологийг сайжруулна.

4.1.2.1. Аймгийн Засаг даргын Тамгын газар болон сум бүрд цахим сургалтын танхим байгуулж, төрийн албан хаагчийн цахим хурал, шалгалт, сургалт зохион байгуулах орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангах

4.1.2.2. Төрийн албан хаагчийн ёс зүй, чадавхжуулах сургалт, арга хэмжээг үе шаттай зохион байгуулах

4.1.2.3. Түвшинширээ суманд Нутгийн удирдлагын ордон шинээр барих, Сүхбаатар аймаг болон Асгат, Баяндэлгэр, Наан сумдын Засаг даргын Тамгын газрын байранд өргөтгөл, их засварын ажил хийх

4.1.2.4. Стандарт, хэмжилзүйн хэлтсийн хэмжилзүйн лабораторид шинээр эталон тоног төхөөрөмжийг суурилуулах

4.1.2.5. Сумдын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт, шалгалтыг тогтмол зохион байгуулах

4.1.2.6. Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн үйл ажиллагааг өргөтгөх

4.1.2.7. Хил хамгаалах, Цагдаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх, Шүүх шинжилгээний байгууллагын үйл ажиллагааны материаллаг баазыг бэхжүүлэх

4.1.2.8. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Авто тавиуланг шинээр барих

4.1.2.9. Шүүхийн шинжилгээний албыг бичиг баримтын болон галт зэвсгийн шинжилгээний тоног төхөөрөмжөөр хангах

4.1.2.10. Аймгийн шүүх, Улсын бүртгэлийн хэлтэс, Авто тээврийн үндэсний төв, Татварын хэлтэст "Гэрэгэ систем"-ийн киоск машин суурилуулах

4.1.2.11. Хууль сахиулах тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын дунд тусгай бэлтгэлийн сургалтын талбай байгуулах

4.1.2.12. Хил хамгаалахад туслах хүчний гишүүдийн зөвлөгөөнийг жил тутам зохион байгуулах

4.1.2.13. Улсын хил хамгаалалтыг бэхжүүлэх хүрээнд хилийн 0146 ангийг нисгэгчгүй дроноор хангах

4.1.2.14. Өөрийн аймгийн хилийн хэсгийн өргөст утсан торыг стандартад нийцүүлэн шинэчлэх ажилд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах

4.1.3. Төрийн байгууллагад ISO олон улсын стандартыг нэвтрүүлж, үйлчилгээний чанарыг сайжруулна.

4.1.3.1. Сумдын Засаг даргын Тамгын газарт "ISO 9001:2015" олон улсын Чанарын менежментийн тогтолцоо стандартыг нэвтрүүлж, баталгаажилт хийлгэх

4.1.3.2. Төр, орон нутгийн бодлого, шийдвэрийн талаарх иргэдийн сэтгэл ханамжийн түвшнийг тодорхойлох хэрэглэгчийн үнэлгээ, судалгааг иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлэх

4.2. Мэргэшсэн, хариуцлагатай төрийн алба

4.2.1. Төрийн албан хаагчийг тогтвортой суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

4.2.1.1. Аймгийн хэмжээний төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх

4.2.1.2. Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах, орон сууцны нөхцөлийг сайжруулах

4.2.2. Төрийн албаны хүний нөөцийг бэлтгэж чадавхжуулна.

4.2.2.1. Төрийн албан хаагчдыг Засгийн газрын болон гадаадын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдалтыг нэмэгдүүлэх

4.2.2.2. Төрийн албан хаагчдыг үе шаттай мэргэшүүлэх сургалтад хамруулах

4.2.3. Хүний эрхийг дээдэлсэн хандлагыг төлөвшүүлж, хүний эрхийн зөрчил шийдвэрлэлтийн хувийг нэмэгдүүлнэ.

4.2.3.1. Хүний эрх, эрх чөлөө, хууль ёсыг дээдлэх хандлага, дадлыг төлөвшүүлэх сургалт сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээг иргэд болон төрийн албан хаагчдад зориулан үе шаттайгаар зохион байгуулах.

4.2.3.2. Хууль зүйн туслалцааны үйлчлэх хүрээг өргөжүүлж, төлбөрийн чадваргүй сэжигтэн яллагдагч, шүүгдэгч, ялтан, зарим эрүүгийн хэргийн хохирогч, оролцогчид үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлж, эрхийг нь хамгаалахад мэргэжлийн байгууллагуудтай хамтарч ажиллах

4.2.4. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх төрийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг иргэд, олон нийтийн оролцоотой төлөвлөн, хэрэгжүүлж шударга байдлын үнэлгээг нэмэгдүүлнэ.

4.2.4.1. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг хангах

4.2.4.2. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх тухай, Төрийн албаны тухай хуулиудын холбогдох заалтуудын хэрэгжилтэд хяналт тавих

4.3. Амар тайван, аюулгүй нийгэм

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, илрүүлэлтийг улсын дунджаас дээш түвшинд хүргэнэ.

4.3.1. Дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг өргөжүүлнэ.

4.3.1.1. Аймаг, сумын төвийн гэрэлтүүлгийг нэмэгдүүлж, камержуулах ажлыг үе шаттай зохион байгуулж, камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлэх

4.3.1.2. Аймгаас гарах, орох төв замуудад дугаар илрүүлэгч бүхий хяналтын камер суурилуулах

4.3.1.3. Баруун-Урт хотын төвд 2019 онд суурилуулсан телекамерын түрээс, цахилгааны төлбөр, засвар үйлчилгээний урсгал зардлыг аймаг, сумын төсөвт суулган жил бүр санхүүжүүлэх.

4.3.1.4. Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор Баруун-Урт, Чингис хот чиглэлийн замд "дундаж хурд тодорхойлох" технологи, туршлагыг судалж нэвтрүүлэх

4.3.1.5. Хүний биеийн давтагдашгүй өгөгдөл, царайгаар таних хяналтын төхөөрөмжүүдийг байрлуулж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх

4.3.1.6. Аж ахуйн нэгж, байгууллага, ялангуяа шатахуун түгээх станц, барьцаалан зээлдүүлэх, интернет тоглоомын газар болон томоохон худалдаа, үзвэр, үйлчилгээний газрууд, гудамж талбайн хяналтын камерын системийг цагдаагийн газрын нэгдсэн сүлжээнд холбох

4.3.1.7. Гэмт халдлагад өртөж болзошгүй эд зүйл, мал, амьтны байршил тогтоох техникийн шийдэл, дэвшилтэт технологи, программ хангамжийг нэвтрүүлэх.

4.3.1.8. Хүн, мал тээврийн хэрэгслийн мэдээллийг шалгах цахим төхөөрөмжөөс хайлт хийх, илрүүлэх зэрэг цахим мэдээллийн санд суурилсан бүртгэл хяналтын системийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрэн сурвалжлах, зарлан мэдээлэх, ажилд өргөнөөр нэвтрүүлж, ашиглах хүртээмжийг нэмэгдүүлэх.

4.3.1.9. Нисгэгчгүй нисэх төхөөрөмж болох “Дроны эргүүл”-ийг бий болгож, эмзэг цэгүүдийг хянаж, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх

4.3.2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэд олон нийтийн оролцоог хангана.

4.3.2.1. Аймгийн хэмжээнд гаралт ихтэй зарим төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн дэргэд Хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, Архидан согтуурахтай тэмцэх, Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх дэд зөвлөлүүдийг байгуулж ажиллуулах

4.3.2.2. Дотоод хэргийн их сургууль болон бусад судалгааны байгууллагатай хамтран аймгийн нутаг дэвсгэрт сүүлийн 10 жилд үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдалд судалгаа, дүн шинжилгээ хийх

4.3.2.3. Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг, гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах зорилгоор Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр баригдсан “Түр хамгаалах байр”-ны урсгал зардлыг шийдвэрлэх

4.3.2.4. Өсвөр үеийнхэн, ерөнхий боловсролын сурагчдыг хар тамхи, мансууруулах бодис хэрэглэх, уруу татагдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор зохих мэдлэг олгох, хар тамхи, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлийг сурталчлах чиглэлээр “Үзүүлэн кабинет” байгуулах.

4.3.2.5. Баруун-Урт хот, Мөнххаан, Түмэнцогт сумдад баригдсан замын хяналтын постын аюулгүй байдлыг хангах зорилгоор стандартын шаардлагад нийцүүлэн тохижуулах

4.3.2.6. Баруун-Урт хотын төв болон хот хоорондын төв магистрал замуудын тэмдэг, тэмдэглэгээнд үзлэг, шалгалт хийж, стандартад нийцүүлэн засаж өөрчлөх, шинээр нэмэгдүүлэх

4.3.2.7. Хот хоорондын замд хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн эсэхийг шалгах тандагч, драгер багажаар хангах

4.3.2.8. Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт, соён гэгээрүүлэх ажил, арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, хуулийн этгээдтэй хамтран тогтмол зохион байгуулах, мэдээлэх.

4.3.2.9. Хүүхдийг багаас нь зөв хүн болгон төлөвшүүлэх, хууль дээдлэх, эрх зүйн боловсрол олгох, аливаа асуудлыг хүчирхийллийн бус аргаар шийдвэрлэх, эрсдэлээс өөрийгөө хамгаалах мэдлэг, соёл, харилцааны ур чадвар олгоход чиглэсэн цогц арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлэх.

4.3.2.10. Тухайн хүн гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх, түүний зан үйл, ёс суртахуунд нөлөөлж, хандлагыг өөрчлөх замаар гэмт үйлдлээс сайн дураараа татгалзах нөлөөллийн арга хэлбэрийг үе шаттай хэрэгжүүлэхэд гэр бүл, ойр дотнын хүмүүсийн дэмжлэгийг авч хамтран ажиллах.

4.3.2.11. Гэмт хэрэг үйлдэж болзошгүй нөхцөлд байгаа болон хорих ял эдлээд суллагдсан этгээдэд хяналт тавих, нийгэмд дасан зохицох, нийгмийн амьдралд эрх тэгш оролцох боломжийг бүрдүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоог нэмэгдүүлж, хамтран ажиллах

4.3.3. Мал хулгайлах гэмт хэргийг иргэдийн оролцоо, дэвшилтэт технологи ашиглан илрүүлэлтийг нэмэгдүүлнэ.

4.3.3.1. Аймгийн хэмжээнд 2018 оноос батлан хэрэгжүүлж буй “Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ хийх

4.3.3.2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг татан оролцуулах, тэдний дэмжлэг туслалцааг авах зорилгоор “Малын хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх сан” -г үүсгэн байгуулах

4.3.3.3. Малчдын бүлгийн ахлагч, гишүүдийг олон нийтийн байцаагчаар томилж, урамшуулал олгох

4.3.4. Орон нутгийн гамшгаас хамгаалах техник тоног төхөөрөмжийг шинэчилж, гамшгийг даван туулах, дасан зохицох чадавхыг бэхжүүлнэ.

4.3.4.1. Онцгой байдлын газрын гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд зориулан машин, техник тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх хүрээнд шуурхай албаны автомашиныг шийдвэрлэх

4.3.4.2. Улсын нөөцийн 016 дугаар цэгийг цахилгаанд холбох

4.3.4.3. Гал унтраах зориулалттай автомеханик шаттай 3,8 м өндөр, 11 м урттай автомашиныг байрлуулах гражийн өргөтгөлд шаардлагатай хөрөнгийг шийдвэрлэх

4.3.4.4. Онцгой байдлын газрын гадна талбай, автомашины гражид асфальтан зам, талбай хийж гал унтраах тусгай зориулалтын автомашинуудын даацын стандартыг хангах

4.3.4.5. Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөр, гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Сүхбаатар аймагт гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх зардлыг шийдвэрлэх

4.3.4.6. “Аймгийн иргэдийг гамшгаас хамгаалах сургалт, аргазүйн танхим” байгуулах

4.4. Тогтвортой, нэгдмэл гадаад харилцаа

4.4.1. Тэргүүлэх салбарт гадаадын хөрөнгө оруулалт татах, төсөл хөтөлбөр, буцалтгүй тусламжийн тоог нэмэгдүүлнэ.

4.4.1.1. Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй хамтран ажиллах боломжтой олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрийн нарийвчилсан судалгааг гаргаж хамтын ажиллагааны уулзалтуудыг зохион байгуулах

4.4.1.2. Олон улсын төсөл хөтөлбөрөөс санхүүжилт татах чадавхыг бэхжүүлэх нэгдсэн сургалт зохион байгуулах

4.4.1.3. KOICA олон улсын байгууллагатай хамтран Солонгос улсаас сайн дурын ажилтан ажиллуулах үйл ажиллагааг зохион байгуулах

4.4.1.4. Тэргүүлэх салбаруудад чиглэсэн төслийн санал боловсруулах

4.4.1.5. БНТУ-ын Самсун мужтай харилцааг сэргээж, албан ёсны хамтын ажиллагааны санамж бичиг байгуулах

4.4.2. БНХАУ-ЫН АЙМАГ, ХОТУУДТАЙ ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЭН АЖИЛЛАНА.

4.4.2.1. БНХАУ-ЫН Шилийн гол аймаг, Хөлөнбуйр аймаг, Тунляо, Улаанхад хотуудтай хамтарсан зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулах

4.4.2.2. БНХАУ-ЫН Ляонин мужтай хамтын ажиллагааг сэргээж санамж бичгийг шинэчлэн байгуулах

4.4.2.3. БНХАУ-ЫН ӨМӨЗО-НЫ Шилийн гол аймгийн ажил мэргэжлийн дээд сургуульд жилд 10 хүртэлх оюутныг хагас болон бүрэн тэтгэлэгтэй суралцуулах ажлыг зохион байгуулах

4.4.2.4. БНХАУ-ЫН ӨМӨЗО-НЫ Хөлөнбуйр, Шилийн гол, Тунляо хотуудад уламжлалт анагаах ухааны чиглэлээр жилд 10 хүртэлх эмч, сувилагчдыг богино болон дунд хугацааны сургалтад хамруулах

4.4.2.5. Аймгийн Уламжлалтын эмнэлгийг БНХАУ-ЫН ӨМӨЗО-Ы Шилийн гол аймгийн Монгол эмнэлгийн хороотой онлайн хамтын ажиллагаатай болгох

4.4.2.6. БНХАУ-ЫН ӨМӨЗО-НЫ хил орчмын аймаг, хошуутай хамtran бизнес эрхлэгчдийн уулзалт, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах

4.4.3. ОХУ-ЫН ХИЛ ОРЧМЫН МУЖ ХОТУУДТАЙ ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛНЭ.

4.4.3.1. Өвөр Байгалийн хязгаартай хамтын ажиллагааг сэргээж, санамж бичиг байгуулах

4.4.4. Нэгдсэн Үндэсний Байгууллагын "Тогтвортой хөгжлийн зорилт – 2030" хөтөлбөрийн хүрээнд "Орон нутагт тогтвортой хөгжлийн зорилтыг нутагшуулах нь" төслийг хэрэгжүүлнэ.

4.4.4.1. Монгол дахь Нэгдсэн үндэсний байгууллагын хөгжлийн хөтөлбөр түүний салбар төслүүдтэй орон нутгийн түвшинд хамtran ажиллах уулзалтыг зохион байгуулах

4.4.4.2. "Идэвхэжсэн 30" залуучуудын хөтөлбөрийг хэрэгжүүлэх

4.4.4.3. "Тогтвортой хөгжлийн зорилт"-ыг нутагшуулах төслийг хэрэгжүүлэх хамтын ажиллагааны санамж бичгийг байгуулах

4.4.4.4. "Тогтвортой хөгжлийн зорилт ба уялдаа холбоо", сэдэвт чадавхыг бэхжүүлэх цуврал сургалтыг сум, агентлагийн хүрээнд зохион байгуулах

4.4.5. "Их түмэн санаачилга" бус нутгийн хамтын ажиллагааны хүрээнд зүүн бүсийн хэмжээнд хамtran оролцно.

4.4.5.1. БНСУ, Япон Улсын муж, хотуудтай хамтын ажиллагаа тогтоох

4.4.5.2. "Их түмэн санаачилга" бус нутгийн хамтын ажиллагааны хорооны уулзалтад идэвхтэй оролцож, тэргүүлэх салбарт хамтарсан төслийн санал боловсруулах

4.4.5.3. БНХАУ-ЫН Ляонин мужийн Жинжөү боомтыг түшиглэн Бичигт боомт болон БНХАУ-ЫН ӨМӨЗО-НЫ Шилийн гол аймгийн Зүүн хатавч боомтоор дамжуулан далайд гарах гарцыг нээх боломж, нөхцөлийн судалгааг БНХАУ-ЫН талтай хамtran боловсруулах

4.5. Батлан хамгаалах

Иргэн цэргийн харилцааг бэхжүүлэн, Улсын батлан хамгаалах эрх ашигт нийцсэн орон нутгийн хамгаалалт, дайчилгааны төлөвлөлтийг боловсронгуй болгоно.

4.5.1. Хүүхэд залуучуудад цэрэг эх оронч хүмүүжлийг төлөвшүүлнэ.

4.5.1.1. Аймгийн хэмжээний ЕБ-ын 10 сургуульд цэрэг дайчдын "Алдарын танхим" байгуулах

4.5.1.2. ЕБ-ын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд аймгийн Засаг даргын нэрэмжит Цэрэг-спортын "Дөл" тэмцээн зохион байгуулах

4.5.2. Дайчилгааны төлөвлөгөөг шинэчилж, томилгоот бүрэлдэхүүнийг чадавхжуулна.

4.5.1. Дайчилгааны төлөвлөгөөг шинэчлэх сургалтыг зохион байгуулах

4.5.2. Цэргийн штаб, анги салбарын сургалтын нэгдсэн төвийг байгуулах

4.5.3. Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөний дагуу нөөц бүрдүүлнэ.

4.5.3.1. Орон нутгийн томилгоот нэгж, түүний удирдлага, бие бүрэлдэхүүний сургалтыг үе шаттай зохион байгуулах.

4.5.3.2. Орон нутгийн хамгаалалтын техник хэрэгсэл, бараа материалын нөөцийг бүрдүүлэх

ТАВ. БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ

5.1. Ногоон хөгжил

Хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулна.

5.1.1. Байгаль орчныг хамгаалах, ногоон хөгжлийн талаарх боловсролыг дээшлүүлнэ.

5.1.1.1. Иргэдэд байгаль хамгаалах, ногоон хөгжлийн боловсрол олгох сургалт, арга хэмжээ зохион байгуулах

5.1.1.2. ЕБС-ийн Эко клубүүдийг чадавхжуулах чиглэлээр төсөл хэрэгжүүлэх

5.1.1.3. Жил бүр 3-аас доошгүй сумын Улсын тусгай хамгаалалтад авах газруудын судалгааг гаргаж, аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан, Засгийн газарт уламжлах

5.1.1.4. Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх

5.1.2. Ойн сан бүхий газрын ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээ болон төв суурин газрын ногоон байгууламжийн ургалтыг хувийг нэмэгдүүлнэ.

5.1.2.1. Цөлжилтийн нарийвчилсан судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, цөлжилтийн атластай болох

5.1.2.2. Ойгоор бүрхэгдсэн талбай хэмжээг нэмэгдүүлэх

5.1.2.3. Эвдэрч, эзэнгүй орхигдсон газарт нөхөн сэргээлт хийх

5.1.2.4. Аймаг, сум, багийн төвд бичил цэцэрлэг, цэцэрлэгт хүрээлэн байгуулах газрыг газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж нөөцдөд авах

5.1.2.5. Мод үржүүлгийн газарт орон нутгийн онцлогт тохирсон модлог ургамлыг үр, мөчрөөр тарималжуулан нөөцийг бүрдүүлэх

5.1.2.6. Баруун-Урт хот, Эрдэнэцагаан, Түмэнцогт, Дарьганга сумдын бичил болон цэцэрлэгт хүрээлэнд гоёл чимэглэлийн мод сөөг ургуулах ажлыг зохион байгуулах

5.1.2.7. Аймгийн төвийн нийтийн эзэмшилийн талбайн ногоон байгууламжийг нэмэгдүүлж, усалж арчлах

5.1.2.8. Аймгийн хэмжээнд “Ногоон хот” хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх

5.1.2.9. Сум дундын болон сумын ойн ангийн техник, тоног төхөөрөмжийг сайжруулах, мэргэжлийн боловсон хүчнийг чадавхжуулах

5.1.2.10. Баруун-Урт хотын 5-р тойргийн зам дагуух модыг хашиж хамгаалах ажлыг дуусгах

5.1.3. Ховордсон биологийн төрөл зүйлийн нөөцийг хамгаалж, сэргээн нутагшуулна.

5.1.3.1. Ургамлын нарийвчилсан судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэж нөөцийг тогтоох

5.3.1.2. Нэн ховор, ховор, ашиглалтад өртөмтгий ургамлыг тарималжуулах, хамгаалах

5.3.1.3. Аймгийн хэмжээнд ерөнхий агнуур зохион байгуулалтын судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэх

5.3.1.4. Халиун бугын Илий, Монгол тарвага сэргээн нутагшуулах /1 суманд 10 толгой халиун бугын илий, 5 суманд 100 толгой тарвага/

5.3.1.5. Зэрлэг амьтдын амьдрах орчин нөхцөлийг сайжруулж, биотехникийн арга хэмжээ авах

5.3.1.6.1. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр нөхөрлөл байгуулах

5.3.1.7. Байгаль хамгаалах үйл ажиллагаанд нөхөрлөлийн оролцоог нэмэгдүүлэх

5.1.4. Усны нөөцийг бохирдол, хомсдолоос хамгаална.

5.1.4.1. Төвлөрсөн ундны усны хамгаалалтын бүсийг тэмдэгжүүлэх

5.1.4.2. Гидрологийн дунд масштабын зураглал хийлгэх

5.1.4.3. Усны сан бүхий газарт хөв цөөрөм, усны сан байгуулах

5.1.4.4. Гүн өрмийн худгуудад зөвшөөрөл олгож паспортжуулах ажлыг зохион байгуулах

5.1.4.5. Булгийн эхийг хашиж хамгаалах, тохижуулах ажлыг зохион байгуулах.

5.1.4.6. Дарьгангын байгалийн цогцолборт газарт байрлах нууруудын ууршилтын судалгаа хийх

5.1.5. Агаар, орчны бохирдлын түвшнийг бууруулна.

5.1.5.1. Агаарын чанарыг хэмждэг багаж тоног төхөөрөмжийн чадавхыг нэмэгдүүлж агаарт агуулагдаж буй 4-5 төрлийн элементийг хэмждэг болох

5.1.5.2. Аймгийн нийт айл өрхийн эко шийдлээр хийгдсэн нүхэн жорлонгийн тоог нэмэгдүүлэх

5.1.5.3. Агаар орчны бохирдлыг бууруулах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх

5.1.5.4. Хог хаягдлыг ангилан ялгах, цуглуулах асуудлыг тусгасан нэгдсэн журам боловсруулах

5.1.5.5. Хог хаягдлыг ангилан ялгах цех байгуулах

5.1.5.6. Дахивар хог авах цэгийн тоог нэмэгдүүлэх

5.1.5.7. Эрүүл ахуйн шаардлага хангасан хогийн цэгийн тоог нэмэгдүүлэх

5.1.5.8. Иргэдэд хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах дадал хэвшлийг суулгах нөлөөллийн ажил зохион байгуулж, эзэнгүй хог хаягдлыг 40 хувиар бууруулах

5.1.5.9. Төв, суурин газарт хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах зориулалт бүхий сав байршуулах ажлыг зохион байгуулах

5.1.5.10. Радарын станц байгуулан хур тунадасны хэмжээг нэмэгдүүлж, байгалийн аюулт үзэгдлийг урьдчилан мэдээлэх чадавхыг бэхжүүлэх

5.1.5.11. Байгалийн аюултай үзэгдлийг урьдчилан мэдээлэх багц мессеж хүлээн авагчдын хүрээг нэмэгдүүлэх

ЗУРГАА. БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ

6.1. Баруун-Урт хот

Амьдрахад таатай, байгаль орчинд ээлтэй, хот болгон хөгжүүлнэ.

6.1.1. Дэд төвийг байгуулна.

6.1.1.1. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу дэд төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж батлуулах

6.1.1.2. Баруун-Урт хотын багуудад гэр хорооллын газрыг шинэчлэн зохион байгуулах

6.1.2. 1500 айлын хороолол төслийг хэрэгжүүлнэ.

6.1.2.1. Хорооллын хэсэгчилсэн төлөвлөлтийн зураг төсөл боловсруулах ажлыг зохион байгуулж, ажлыг эхлүүлэх

6.1.3. Баруун-Урт хотод иргэдийн амрах, зугаалах газар, бичил цэцэрлэг, цэцэрлэгт хүрээлэнгийн талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.

6.1.3.1. Уртын голын дагуу тохижилтын ажлыг хийх

6.1.3.2. Хүүхдийн парк барих

6.1.3.3. Морьтой хөшөөний ажлыг үргэлжлүүлэн барих

6.1.3.4. Эко хороололд цэцэрлэгт хүрээлэн шинээр барих, Барилгачдын цэцэрлэгт хүрээлэнг сэргээн засварлах

6.1.4. Баруун-Урт хотын хатуу хучилттай авто зам, замын байгууламжийг өргөтгөн шинэчилнэ.

6.1.4.1. Аймгийн төвийн 4-р тойргийн 9.1 км хатуу хучилттай авто зам, замын байгууламжийн ажлыг дуусгаж, 5-р тойргийн 5.65 км, Баруун-Урт хотын 1-р багийн Цэргийн анги, Ахмадын сувилал орчмын 3.03 км хатуу хучилттай авто зам, замын байгууламжийг ашиглалтад оруулах

6.1.4.2. Баруун-Урт хотын 5, 9-р баг, Дөрвөлж цэцэрлэгт хүрээлэнгээс Сүхбаатар сумын гарц чиглэлд 1.5 км, 4-р багаас Түмэнцогт сумын гарц чиглэлд 560 м, Баруун-Урт хотоос Асгат сум руу гарах Зээрийн хөшөө чиглэлд 1.5 км, 6-р баг гэр хорооллын дунд 1,2 км, Боловсрол, Эко, Ургах наран хорооллын дунд хатуу хучилттай авто зам, замын байгууламжийг тус тус барих

6.1.4.3. Жил бүр аймгийн төвийн хатуу хучилттай авто замуудад их засвар, нөхөөс тавих ажлыг хийж гүйцэтгэх

6.1.4.4. Баруун-Урт хотын төв, гэр хороолол дундах авто зам дагуух явган зам барих ажлыг үе шаттай хийж гүйцэтгэх

6.1.4.5. Баруун-Урт хотын хатуу хучилттай авто замын уулзваруудад гэрлэн дохио, хяналтын камер суурилуулах ажлыг хийж гүйцэтгэх

6.1.4.6. Баруун-Урт хотын төвийн хатуу хучилттай авто замын дагуу болон уулзвар гарцуудад тэмдэг, тэмдэглэгээг шинэчлэн сайжруулах

6.1.5. Баруун-Урт нисэх буудлын үйл ажиллагааг өргөжүүлж, УБ-Баруун-Урт чиглэлийн нислэгийг сэргээнэ.

6.1.5.1. Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд УБ-Баруун-Урт чиглэлийн нислэг сэргээх ажлыг эрчимжүүлж, Баруун-Урт нисэх буудлын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах

6.1.6. Баруун-Урт хотод Нийтийн тээврийн үйлчилгээ нэвтрүүлнэ.

6.1.6.1. Баруун-Урт хотод нийтийн тээврийн үйлчилгээг эхлүүлж, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх

6.1.7. Цахилгаан, дулаан, эрчим хүчний станцын өргөтгөл, шинэчлэл засвар хийнэ.

6.1.7.1. Баруун-Урт хотын 1-7 дугаар багийн дулаан, хэрэглээний халуун хүйтэн усны шугам сүлжээний их засварын ажил хийх

6.1.7.2. 8, 9 ДДТ-ийн барилгыг, шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн хамт барих

6.1.7.3. Баруун-Урт хотын Дулааны станцын өргөтгөлийн барилгын гадна инженерийн шугам сүлжээний ажлыг хийх

6.1.7.4. Дулааны станцын 2 зууханд тоолуур, хуваарилах конверт жин хэмжигч, нүүрсний шинжилгээний төхөөрөмж суурилуулж, 2-р зуухны утаа сорогчийг шинэчлэх

6.1.7.5. Эрчим хүчний шинэ эх үүсвэрийн ТЭЗҮ боловсруулах ажлыг эхлүүлэх

6.1.7.6. 24-ийн зууханд сүлжээний усны 3 ширхэг насосыг өргөтгөж, тоног төхөөрөмжийг шинэчлэн сайжруулах

6.1.7.7. Залуус, Бичил хорооллын дулаан, хэрэглээний халуун ус, цэвэр усны гол түгээх шугамын өргөтгөлийг хийх

6.1.7.8. ДДТ-ийн дулаан, цэвэр усны шугам сүлжээг авто замын ажилтай холбогдуулан шилжүүлэх ажлыг хийх

6.1.7.9. Дулааны эрчим хүч хэмнэлтийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллах

6.1.7.10. Дулаан алдагдлыг бууруулах зорилгоор нийтийн хуучны орон сууцнуудыг дулаалах ажлыг хэрэгжүүлэх

6.1.7.11. Баруун-Урт хотын Хойд-Өндөр 2-ын 10кВ-ын шугамын өргөтгөл хийх

6.1.7.12. Хэрэглээний өсөлттэй холбогдуулан 110/35/10кВ-ын Баруун-Урт дэд станцын өргөтгөл шинэчлэл хийх

6.1.8. Аймгийн төвийн гэрэлтүүлгийг нэмэгдүүлэн ашиглалтыг сайжруулна.

6.1.8.1. Баруун-Урт хотын 2, 3, 4, 5, 9-р багийн гэр хороололд цамхагт гэрэлтүүлгийн ажлыг хийх

6.1.8.2. Төвийн хатуу хучилттай авто зам дагуух гэрэлтүүлгийг шинэчлэх

6.1.9. Мэдээлэл холбооны суурь дэд бүтцийг өргөтгөнө.

6.1.9.1. Жавхлант хаус хороолол, Эко, Боловсрол, Жавхлант хорсоллууд руу холбоо хангамжийн сувагчлал татаж, утастай болон утасгүй интернетийн сүлжээнд холбох

6.2. Сумдын хөгжил

Бүс, орон нутаг, хөдөөгийн хөгжлийг дэмжиж, дэд бүтцийг хөгжүүлэн орон нутаг дахь иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ.

6.2.1. Сумдыг төвлөрсөн ус, дулаан, ариутгах татуургын шугам сүлжээ, ариун цэврийн байгууламжийн хангамжтай болгож, ашиглалтыг сайжруулна.

6.2.1.1. Асгат, Уулбаян, Баяндэлгэр, Түвшинширээ, Мөнххаан сумдад төвлөрсөн халаалтын уурын зуух барих

6.2.1.2. Дарьганга, Халзан, Асгат, Эрдэнэцагаан, Онгон, Сүхбаатар сумдыг цэвэр ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээнд холбож, цэвэрлэх байгууламж барих

6.2.1.3. Наран, Халзан, Онгон, Дарьганга сумдын дулаан хангамжийн эх үүсвэрийн өргөтгөл, шинэчлэлт хийх

6.2.2. Аймгийн төвийг зарим сумдын төвүүдтэй хатуу хучилттай авто замаар холбоно.

6.2.2.1. Баруун-Урт-Асгат-Эрдэнэцагаан сумыг хатуу хучилттай авто замаар холбох ажлыг эхлүүлэх

6.2.2.2. Баруун-Урт-Сүхбаатар сум чиглэлийн 59 км, Баруун-Урт-Уулбаян сум чиглэлийн 45 км хатуу хучилттай авто зам барих ажлыг эхлүүлэх

6.2.2.3. Эдийн засгийн үр ашигтай, аялал жуулчлал, хөдөө аж ахуйн тээврийг дэмжсэн “Нутгийн зам” төслийн хүрээнд “Арбулаг 60-ын овоо” чиглэлд 60 км хатуу хучилттай авто зам барих

6.2.3. Сумдын төвийн авто зам, замын байгууламжийн сүлжээг өргөтгөнө.

6.2.3.1. Сүхбаатар, Эрдэнэцагаан, Мөнххаан сумын төвд 2 км, Халзан, Асгат сумын төвд 1,5 км хатуу хучилттай авто зам, замын байгууламж барих

6.2.3.2. Дарьганга сумын төвд баригдаж байгаа 2.3 км хатуу хучилттай авто зам, замын байгууламжийг дуусган ашиглалтад оруулах

6.2.4. Алслагдсан сумдад агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээ, ерөнхий зориулалтын нислэг үйлдэх зурvas газрыг тогтоож, хамгаалалтад авна.

6.2.4.1. Эрдэнэцагаан, Бичигт боомт, Дарьганга, Онгон, Наран, Баяндэлгэр сумдад нислэгийн зурvas байгуулан, хамгаалалтын бүс тогтоох

6.2.5. Хот, сум хоорондын зорчигч тээврийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.

6.2.5.1. Аймгийн төвд стандарт шаардлага хангасан зорчигч тээврийн нэгдсэн авто вокзал байгуулах

6.2.5.2. Хот, сум хоорондын зорчигч тээврийн үйлчилгээг сайжруулах

6.2.6. Өсөн нэмэгдэж буй хэрэгцээтэй уялдуулан цахилгаан дамжуулах агаарын шугамыг өргөтгөнө.

6.2.6.1. Сүхбаатар, Түвшинширээ сумын 10кВ-ын ЦДАШ-ын шинэчлэл хийх

6.2.6.2. Уулбаян сумын 35кВ-ын ЦДАШ-ын АС-70 хөнгөн цагаан дамжуулагчийг АС-95 болгон өргөтгөх

6.2.6.3. Наран, Мөнххаан, Түвшинширээ, Онгон, Дарьганга сумын АС уастай модон тулгууртай ЦДАШ-ыг төмөр бетонон тулгууртай СИП уастай болгон шинэчлэх

6.2.6.4. Шинэ суурьшлын бүсийн гадна цахилгаан хангамжийн 10/0.4кВ-ын 250кВ-ын дэд станц, 0.4кВ-ын ЦДАШ-ын угсралт хийх

6.2.7. Сумдын төвийн гэрэлтүүлгийг нэмэгдүүлэн ашиглалтыг сайжруулна.

6.2.7.1. Сумдын төвийн гэр хороолол, зам, талбай, гудамжны гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх

6.2.7.2. Сумдын төвийг орчин үеийн, эрчим хүчний хэмнэлттэй гэрэлтүүлгээр үе шаттай шинэчлэх ажлыг зохион байгуулж, ашиглалтыг сайжруулах

6.2.8. Хээрийн сайт барьж үүрэн холбооны сүлжээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

6.2.8.1. Сум суурин газраас алслагдмал айл өрх, аялал жуулчлалын бүс нутагт сайт байгуулах

6.2.9. Мэдээлэл холбооны суурь дэд бүтцийг өргөтгөнө.

6.2.9.1. Бичигт боомтыг шилэн кабелийн сүлжээнд холбох

СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР